



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/275

Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож, захиалагчийн  
төлөөлөгч томилж, ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дүгээр зүйлийн 30.1, 48 дугаар зүйлийн 48.2.6, 48.2.7, 48.2.9, Засгийн газрын 2023 оны “Журам батлах тухай” 278 дугаар тогтоол, Сангийн сайдын 2023 оны “Бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг батлах тухай” А/258 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны “Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг батлах тухай” А/95 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжихээр батлагдсан Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж (Хөвсгөл, Арбулаг, Ханх, Цагааннуур, Шинэ-Идэр, Төмөрбулаг, Ренчинлхүмбэ, Галт, Тосонцэнгэл, Тариалан, Рашаант, Цагаан-Үүр сум) ЗГХЭГ/20240102019/ дугаартай УАЗ Хантер авто машин /Хөвсгөл хүрээнд Шинэ-Идэр, Төмөрбулаг, Галт, Рашаант, Ханх, Цагаан-Үүр сумдын Засаг даргын Тамгын газарт/ 1 дүгээр Багцийг нийлүүлэхээр 532,000,000 (Таван зуун гучин хоёр сая) төгрөгийн үнийн санал ирүүлсэн “ОТТОМИР” ХХК-ийн тендерийг зөвшөөрч, тус компанид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. “ОТТОМИР” ХХК-тай гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, нийлүүлэх барааны чанар байдал, гэрээний нөхцөлүүдийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий “Захиалагчийн төлөөлөгч”-өөр аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-г томилж, бараа, үйлчилгээ хүлээн авах, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Захиалагчийн төлөөлөгч:

Б.Оюунтуяа

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хөрөнгө  
оруулалтын хэлтсийн дарга)

Ажлын хэсгийн гишүүд:

Б.Баярмаа

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн  
Ахлах мэргэжилтэн)

Б.Цэнддэлгэр

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын  
өмчийн бүртгэл ашиглалт хариуцсан  
Ахлах мэргэжилтэн)

Т.Отгонбаяр

(“Оттомир” ХХК-ийн захирал)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Ё.Ариунзаяа

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө  
оруулалтын хэлтсийн Авто тээврийн

d/A4


6717010852

улсын байцаагч)

3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжихээр батлагдсан Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж (Хөвсгөл, Арбулаг, Ханх, Цагааннуур, Шинэ-Идэр, Төмөрбулаг, Ренчинлхүмбэ, Галт, Тосонцэнгэл, Тариалан, Рашаант, Цагаан-Үүр сум) Багц 1-ийн гүйцэтгэгчийн гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, гэрээний хэрэгжилтийг хангах, барааг (үйлчилгээ) хүлээн авах, гэрээг дүгнэх, санхүүжилтийн гүйцэтгэл баталгаажуулах, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн тухай ажлын үр дүнг тайлагнах, тайланг хавтаст хэрэг болгон Худалдан авах ажиллагааны газрын архивд шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг захиалагчийн төлөөлөгч (Б.Оюунтуяа)-д, захиалагч, тендерт оролцогчийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээ дүгнэсэн акт, бараа (үйлчилгээ) хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг хуульд заасан бусад баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр хавтаст хэрэг болгон Худалдан авах ажиллагааны газрын архивд шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Х.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсорогдог)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ